

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

### Ангиллын код

<p><b>Тохирлын үнэлгээ-Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага</b>  <b>10-р хэсэг. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд аудит хийх, баталгаажуулах чадамжийн шаардлага</b></p>	<p><b>MNS ISO/IEC TS 17021-10:2024</b></p>
<p><b>Conformity assessment-Requirements for bodies providing audit and certification of management systems</b>  <b>Part 10: Competence requirements for auditing and certification of occupational health and safety management systems</b></p>	<p><b>ISO/IEC TS 17021-10:2018</b></p>

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны дугаар сарын ...-ны өдрийн .... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2024 оны ... -р сарын ....ны өдрөөс эхлэн хүчинтэй.

<p><b>1 Хамрах хүрээ</b>  Энэхүү баримт бичигт хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ) менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтын үйл явцад оролцож буй ажилтнуудад тавигдах үр чадварын нэмэлт болон ISO/IEC 17021-1-ийн одоо байгаа шаардлагуудыг тодорхойлсон. Гурван төрлийн ажилтны ба баталгаажуулалтын чиг үүргийг тодорхойлсон:</p>	<p><b>1.Scope</b>  This document specifies additional competence requirements for personnel involved in the audit and certification process for an occupational health and safety (OH&amp;S) management system and complements the existing requirements of ISO/IEC 17021-1.  Three types of personnel and certification functions are defined:</p>
<p>- аудиторрууд;</p>	<p>- auditors;</p>
<p>- аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнууд;</p>	<p>- personnel reviewing audit reports and making certification decisions;</p>
<p>- бусад ажилтнууд.</p>	<p>- other personnel.</p>
<p><b>ТАЙЛБАР:</b> Энэхүү баримт бичиг нь ISO 45001 стандартад суурилсан ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтад хамаарна. Үүнийг ХЭМАБ-ын бусад хэрэглээнд ч ашиглаж болно.</p>	<p><b>NOTE:</b> This document is applicable for auditing and certification of an OH&amp;S management system based on ISO 45001. It can also be used for other OH&amp;S applications.</p>

<p><b>2 Норматив эшлэл</b></p> <p>- Дараах баримт бичгүүдийн зарим хэсэг эсвэл бүхэлдээ агуулгаараа энэхүү баримт бичгийн шаардлагыг бүрдүүлж, бичвэрт эш татсан. Хугацаа заасан ээшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэл хамаарна. Хугацаа заагаагүй ээшлэлийн хувьд тухайн баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (өөрчлөлтийг оруулаад) хамаарна.</p>	<p><b>2 Normative references</b></p> <p>- The following documents are referred to in the text in such a way that some or all of their content constitutes requirements of this document. For dated references, only the edition cited applies. For undated references, the latest edition of the referenced document (including any amendments) applies.</p>
<p>- ISO/IEC 17021-1:2015, Тохирлын үнэлгээ-Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт хийдэг байгууллагад тавих шаардлага-Хэсэг 1: Шаардлага</p>	<p>- ISO/IEC 17021-1:2015, Conformity assessment-Requirements for bodies providing audit and certification of management systems-Part 1: Requirements</p>
<p>- ISO 45001, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх зааврын хамт.</p>	<p>- ISO 45001, Occupational health and safety management systems — Requirements with guidance for use</p>
<p><b>3. Нэр томъёо, тодорхойлолт</b></p> <p>Энэхүү баримт бичигт ISO/IEC 17021-1 болон ISO 45001-д заасан нэр томъёо, тодорхойлолтууд хамаарна. ISO болон IEC нь стандартчилалд ашиглах нэр томъёоны мэдээллийн санг дараах хаягаар хөтөлдөг:</p>	<p><b>3 Terms and definitions</b></p> <p>For the purposes of this document, the terms and definitions given in ISO/IEC 17021-1 and ISO 45001 apply. ISO and IEC maintain terminological databases for use in standardization at the following addresses:</p>
<p>- ISO онлайн хайлтын платформ: <a href="https://www.iso.org/obp">https://www.iso.org/obp</a> хаягаас</p>	<p>- ISO Online browsing platform: available at <a href="https://www.iso.org/obp">https://www.iso.org/obp</a></p>
<p>- IEC Electropedia: <a href="http://www.electropedia.org/">http://www.electropedia.org/</a> хаягаас</p>	<p>- IEC Electropedia: available at <a href="http://www.electropedia.org/">http://www.electropedia.org/</a></p>
<p><b>3.1 хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын техникийн салбар</b></p> <p>ХЭМАБ-ын техникийн салбар нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд хамаарах үйл явцын нийтлэг шинж чанар, түүний төлөвлөсөн үр дүнгээр тодорхойлогддог</p>	<p><b>3.1 occupational health and safety technical area</b></p> <p>OH&amp;S technical area characterized by commonalities of processes relevant to an occupational health and safety management system and its intended results</p>

<p><b>4 Чадамжийн шаардлага</b>  Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021-1:2015, Хүснэгт А.1-д дурьдсанаар баталгаажуулалтын чиг үүрэг тус бүрийн чадамжийн шаардлагыг тодорхойлно.  Эдгээр ур чадварын шаардлагыг тодорхойлохдоо баталгаажуулалтын байгууллага ISO/IEC 17021-1-д заасан болон энэ баримт бичгийн 5, 6, 7-р зүйлд заасан ур чадварын шаардлага, баталгаажуулалтын байгууллагаас тодорхойлсон ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах зүйлүүдийг багтаан бүх шаардлагыг харгалзан үзнэ. Өөрөөр заагаагүй бол 5, 6, 7-р зүйлд дурьдсан ХЭМАБ-ын чадамжийн шалгуурууд нь ХЭМАБ-ын техникийн салбараас үл хамаарна. А хавсралтад ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтын талаарх мэдлэгийн хураангуйг оруулсан болно.</p>	<p><b>4 Competence requirements</b>  The certification body shall define the competence requirements for each certification function as referenced in ISO/IEC 17021-1:2015, Table A.1. When defining these competence requirements, the certification body shall take into account all the requirements specified in ISO/IEC 17021-1, as well as the competence requirements specified in Clauses 5, 6 and 7 of this document, including those that are relevant for the OH&amp;S technical area as defined by the certification body. Unless otherwise stated, the OH&amp;S competence criteria mentioned in Clauses 5, 6 and 7 are independent of any OH&amp;S technical area. Annex A provides a summary of the knowledge for OH&amp;S management system auditing and certification.</p>
<p><b>ТАЙЛБАР:</b> Аудиторын үүрэг бол хяналтын ажилтны ажилтай адил биш.</p>	<p><b>NOTE</b> The role of an auditor is not the same as that of a work inspector.</p>
<p><b>5 ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитуудад тавигдах чадамжийн шаардлага</b></p>	<p><b>5 Competence requirements for OH&amp;S management system auditors</b></p>
<p><b>5.1 Ерөнхий зүйл</b>  Аудитын баг нь аудит хийх хамтын чадамжтай адиторуудаас (шаардлагатай бол техникийн шинжээч) бүрдэнэ.  ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитор бүр ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны үйл ажиллагаа, түүний үйл явц нь аюулгүй, эрүүл ажлын байраар хангах, осол гэмтэл, эрүүл мэндийг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилтот үр дүнд хүрэхийн тулд хэрхэн харилцан үйлчилдэг талаар мэдлэгтэй байна.</p>	<p><b>5.1 General</b>  An audit team shall be composed of auditors (and technical experts, as necessary) having the collective competence to undertake the audit.  Each OH&amp;S management system auditor shall have knowledge of the synergy within an OH&amp;S management system and how its processes interact to meet its intended outcomes of providing a safe and healthy workplace and the prevention of injury and ill health.</p>
<p><b>ТАЙЛБАР:</b> Аудитын багийн гишүүн бүр ижил чадамжтай байх шаардлагагүй, гэхдээ аудитын багийн хамтын чадамж нь аудитын зорилгод хүрэхэд хангалттай байна.</p>	<p><b>NOTE</b> It is not necessary for each member of the audit team to have the same competence, however, the collective competence of the audit team needs to be sufficient to achieve the audit objectives.</p>

<p><b>5.2 ХЭМАБ-ын нэр томьёо, зарчим, үйл явц, үзэл баримтлал</b> ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитор бүр, ХЭМАБ-ын менежментийн нэр томьёо, зарчим, үйл явц, үзэл баримтлалын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдлэгтэй байна. ХЭМАБ-ын болон ХЭМАБ-ын менежментийн нэр томьёо, зарчим, үйл явц, ойлголтууд нь дараах мэдээллээр хязгаарлагдахгүй:</p>	<p><b>5.2 Terminology, principles, processes and concepts of OH&amp;S</b> Each OH&amp;S management system auditor shall have and maintain up-to-date knowledge of terminology, principles, processes and concepts of OH&amp;S and OH&amp;S management. Terminology, principles, processes and concepts of OH&amp;S and OH&amp;S management include, but are not limited to:</p>
<p>- ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны төлөвлөсөн үр дүн(үүд);</p>	<p>- intended outcome(s) of the OH&amp;S management system;</p>
<p>- аюул ба ХЭМАБ-ын эрсдэл;</p>	<p>- hazards and OH&amp;S risks;</p>
<p>- эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах эсвэл бууруулах;</p>	<p>- minimizing or reducing risks;</p>
<p>- хяналтын шатлал;</p>	<p>- hierarchy of control;</p>
<p>- худалдан авалт (аутсорсинг, гүйцэтгэгчийг оролцуулан);</p>	<p>- procurement (including outsourcing and contractors);</p>
<p>- гүйцэтгэсэн ажилд хяналт тавих.</p>	<p>- shared control over work performed.</p>
<p><b>5.3 Байгууллагын төлөв байдал</b> Байгууллагын ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээ, үүнд тухайн байгууллагын нөхцөл байдал, ажилтай холбоотой үйл ажиллагааны хүрээг зохих ёсоор байгаа эсэхийг тодорхойлохын тулд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн гишүүд нь дараах мэдлэгтэй байна:</p>	<p><b>5.3 Context of the organization</b> In order to determine that an organization has appropriately identified the scope, including boundaries and applicability of its OH&amp;S management system, within the organization's context and its work-related activities, personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of:</p>
<p>- ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны зорилтот үр дүнд хүрэхэд нөлөөлж болох гадаад болон дотоод асуудлуудыг тухайн байгууллага тодорхойлсон эсэхийг тогтоохын тулд байгууллагын нөхцөл байдалд хамааралтай болзошгүй асуудлууд;</p>	<p>-potential issues relevant to the context of an organization, in order to determine whether the organization has identified external and internal issues that can affect the organization's ability to achieve the intended outcome(s) of its OH&amp;S management system;</p>
<p>- байгууллага нь ажилчид болон бусад сонирхогч талуудын холбогдох хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлсон эсэхийг тогтоохын тулд ажилчдаас гадна бусад сонирхогч талууд.</p>	<p>-potential other interested parties in addition to workers, in order to determine if an organization has identified the relevant needs and expectations of workers and other interested parties.</p>

<p><b>5.4 Ажилчдын манлайлал, зөвлөгөө, оролцоо</b>  ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн гишүүд нь байгууллагын манлайлал, соёлын үүрэг, нөлөөллийн талаар мэдлэгтэй байна. Энэхүү мэдлэгийг байгууллагын дээд удирдлага нь ХЭМАБ-ын менежментийн тогтолцоонд тууштай хандаж, зорьсон үр дүндээ хүрч байгаа эсэхийг үнэлэхэд хэрэглэнэ.  ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн ажилтнууд нь аливаа байгууллагад ажилчдын зөвлөлдөөн, оролцоог хангах үр дүнтэй үйл явц байгаа эсэхийг тодорхойлохын тулд хүндрэл, саад бэрхшээлийг багтаасан зөвлөлдөх, оролцох арга зүйн талаар мэдлэгтэй байвал зохино.</p>	<p><b>5.4 Leadership, consultation and participation of workers</b>  Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of the role and impact of leadership and culture on an organization. This knowledge shall be applied to evaluate whether the top management of an organization is demonstrating its commitment to the OH&amp;S management system and achieving its intended outcome(s).  Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of methodologies for consultation and participation, including obstacles and barriers, in order to determine whether an organization has effective processes for consultation and participation of workers and, when they exist, workers' representatives.</p>
<p><b>5.5 Хуулийн болон бусад шаардлага</b>  ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багт оролцогч ажилтан нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр байгууллагад хууль эрх зүйн шаардлага болон бусад шаардлагуудыг тодорхойлох, хэрэглэх, үе үе хянаж байх үйл явц байгаа эсэхийг үнэлэхийн тулд ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах зүйлсийг оролцуулан, хуулийн шаардлага болон бусад шаардлагын талаар мэдлэгтэй байх ба үүнд:</p>	<p><b>5.5 Legal requirements and other requirements</b>  Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of legal requirements and other requirements in the field of health and safety at work, including those relevant to the OH&amp;S technical area, in order to evaluate whether an organization has a process to determine, apply and periodically review its legal requirements and other requirements, including those related to:</p>
<p>- байгаа бол ажилчид, ажилчдын төлөөлөгчдийн зөвлөлгөө, оролцоо;</p>	<p>- consultation and participation of workers and workers' representatives, where they exist;</p>
<p>- эрүүл мэндийн хувийн мэдээллийн нууцлал;</p>	<p>- the privacy of personal medical information;</p>
<p>- эрүүл мэнд, аюулгүй байдлын хороодыг байгуулах.</p>	<p>- establishment of health and safety committees.</p>

<p><b>5.6 ХЭМАБ-ын эрсдэл ба боломж болон бусад эрсдэл ба боломж</b></p> <p><b>5.6.1 Эрсдэл ба боломж</b></p> <p>ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн ажилтнууд байгууллага нь байгууллагын нөхцөлд болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хүрээнд аюулыг тодорхойлох, ХЭМАБ-ын эрсдэл, ХЭМАБ-ын боломж болон бусад эрсдэл болон бусад боломжийг тодорхойлоход тохиромжтой аргуудыг ашигласан эсэхийг үнэлэх зорилгоор эрсдэл, боломж, түүний дотор ХЭМАБ-ын техникийн чиглэлээр холбогдох мэдлэгтэй байна.</p>	<p><b>5.6 OH&amp;S risks, OH&amp;S opportunities and other risks and other opportunities</b></p> <p>5.6.1 Risks and opportunities</p> <p>Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of risks and opportunities, including those relevant to the OH&amp;S technical area, in order to evaluate whether an organization has applied appropriate methods for identifying hazards and determining OH&amp;S risks, OH&amp;S opportunities and other risks and other opportunities in an organizational context and within the scope of the OH&amp;S management system.</p>
<p><b>ТАЙЛБАР:</b> Эрсдэл, боломжийг тодорхойлох холбогдох арга, шалгуурын жишээнд даалгаврын дүн шинжилгээ, аюул, ашиглалтын судалгаа (HAZOPS) болон бүтэлгүйтлийн горим, үр нөлөөний шинжилгээ (FMEA) зэрэг чанарын болон тоон шинжилгээ багтаж болно.</p>	<p><b>NOTE:</b> Examples of relevant methods and criteria for determining risks and opportunities can include qualitative and quantitative analysis such as task analysis, hazard and operability studies (HAZOPS) and failure mode and effects analysis (FMEA).</p>
<p><b>5.6.2 Аюулыг тодорхойлох</b></p> <p>ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн ажилтнууд нь аюулыг тодорхойлохдоо тухайн байгууллага нь байгууллагын нөхцөл байдал болон түүний хүрээнд зохих аргыг ашигласан эсэхийг үнэлэхийн тулд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээнд ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах аюулын талаарх мэдлэгтэй байна.</p> <p>Аюулын талаарх мэдлэгт дараах ангилалд хамаарах зүйлс орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:</p>	<p><b>5.6.2 Hazard identification</b></p> <p>Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of hazards, including those relevant to the OH&amp;S technical area, in order to evaluate whether an organization has applied appropriate methods for identifying hazards in an organizational context and within the scope of the OH&amp;S management system.</p> <p>Knowledge of hazards shall include, but not be limited to, those in the following categories:</p>
<p>- физикийн;</p>	<p>- physical;</p>
<p>- химийн;</p>	<p>- chemical;</p>
<p>- биологийн;</p>	<p>- biological;</p>
<p>- физиологийн;</p>	<p>- physiological;</p>
<p>- механикийн;</p>	<p>- mechanical;</p>
<p>- цахилгааны;</p>	<p>- electrical;</p>
<p>- сэтгэлзүйн;</p>	<p>- psychosocial;</p>
<p>-хөдөлгөөн ба энерги дээр суурилсан.</p>	<p>- based on movement and energy.</p>
<p>Аюул ба тэдгээрийн эх үүсвэрийн талаарх мэдлэгийг дараах зүйлээр хязгаарлахгүй:</p>	<p>Knowledge of hazards and their sources shall include, but not be limited to:</p>
<p>-дотоод болон гадаад эх үүсвэр, нөхцөл байдал;</p>	<p>- internal or external sources or situations;</p>

- болзошгүй онцгой нөхцөл байдал;	- potential emergency situations;
- олон ажил олгогчийн ажлын байр;	- multi-employer workplaces;
- ажлын байр, байгууламж;	- workplace and facility;
-бүтээгдэхүүн, үйлчилгээний зураг төсөл, судалгаа, боловсруулалт, сорилт, үйлдвэрлэл, угсралт, барилга угсралт, үйлчилгээ үзүүлэх, засвар үйлчилгээ, устгал;	- product and service design, research, development, testing, production, assembly, construction, service delivery, maintenance and disposal;
- худалдан авалт, гүйцэтгэгч, аутсорсинг;	- procurement, contractors and outsourcing;
- шинэ технологи, тэдгээрийн хэрэглээ;	- new technologies and their application;
- төлөвлөсөн эсвэл төлөвлөөгүй өөрчлөлт;	- planned or unintended changes;
-ажлын зохион байгуулалт, хүний болон нийгмийн хүчин зүйлс.	- work organization, human and social factors.
<b>5.6.3 ХЭМАБ-ын эрсдлийн үнэлгээ</b> ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн гишүүд нь аюулыг тодорхойлох арга зүй, шалгуур үзүүлэлтүүд, түүний дотор ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах эрсдэлийг үнэлэх талаар мэдлэгтэй байх ба ХЭМАБ-ын эрсдэлийг үнэлэх, байгууллагын хүрээнд болон ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хүрээнд арга зүй, шалгуурыг оновчтой, идэвхтэй, системтэй ашиглана.	<b>5.6.3 Assessment of OH&amp;S risks</b> Personnel on a team involved in OH&S management system auditing shall have knowledge of the methodologies and criteria for the identification of hazards and the assessment of OH&S risks, including those relevant to the OH&S technical area, in order to evaluate whether an organization has applied methodologies and criteria in an appropriate, proactive and systematic way in an organizational context and within the scope of the OH&S management system.
<b>5.6.4 ХЭМАБ-ын боломж</b> ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн гишүүд нь ХЭМАБ-ын гүйцэтгэлийг сайжруулахад хүргэж болох үйл явцын төрлийг мэддэг байна. Үйл явцын талаархи мэдлэг нь үүгээр хязгаарлагдахгүй:	<b>5.6.4 OH&amp;S opportunities</b> Personnel on a team involved in OH&S management system auditing shall have knowledge of the type of processes that can lead to improvement of OH&S performance. Knowledge of processes shall include but not be limited to:
- ажлыг ажилтанд тааруулах;	- adapting work to workers;
- ажлын зохион байгуулалтыг өөрчлөх;	- changing the work organization;
-ажлын байрны зохион байгуулалтыг өөрчлөх;	- changing the workplace layout.

<p><b>5.7 Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ</b> ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитын багийн гишүүд нь тухайн байгууллага дараах зүйлийг зохих ёсоор хангасан эсэхийг үнэлэхийн тулд байгууллагын нөхцөл байдалд ХЭМАБ-ын техникийн салбарт хамааралтай байж болзошгүй онцгой нөхцөл байдал, тэдгээрийн хариу арга хэмжээний талаар мэдлэгтэй байна. Үүнд:</p>	<p><b>5.7 Emergency preparedness and response</b> Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of potential emergency situations and their usual responses, including those relevant to the OH&amp;S technical area in an organizational context, in order to evaluate whether an organization has appropriately:</p>
<p>- болзошгүй онцгой нөхцөл байдлыг тодорхойлох;</p>	<p>- identified its potential emergency situations;</p>
<p>- онцгой байдлын хариу арга хэмжээг төлөвлөж туршигдаа гадны хариуцагчдыг хамаатуулж оролцуулна;</p>	<p>- planned and tested its emergency responses, including with respect to external responders;</p>
<p>- төлөвлөсөн онцгой байдлын арга хэмжээнүүд болон шаардлагатай бол бодит онцгой байдлын үед өгсөн хариу арга хэмжээг турших, үр дүнтэй байдлыг үнэлэх.</p>	<p>- evaluated its effectiveness in testing its planned emergency responses and responses given to actual emergencies, if applicable.</p>
<p><b>5.8 Гүйцэтгэлийн үнэлгээ</b> ХАБЭА-ын менежментийн тогтолцооны аудитад хамрагдсан багийн ажилтнууд нь байгууллага ХЭМАБ-ын үйл ажиллагааны үнэлгээний зохих аргууд, үүнд идэвхтэй болон идэвхгүй, чанарын болон тоон үзүүлэлтүүдийг ашигласан эсэхийг үнэлэх, ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны зорилтот үр дүнд хүрч байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор гүйцэтгэлийн үнэлгээний мэдлэгтэй байна.</p>	<p><b>5.8 Performance evaluation</b> Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of performance evaluation in order to evaluate whether an organization has applied appropriate OH&amp;S performance evaluation methods, including proactive and reactive, qualitative and quantitative indicators, and to determine whether it is achieving the intended outcome(s) of its OH&amp;S management system.</p>
<p><b>5.9 Аюулыг арилгах, ХЭМАБ-ын эрсдэлийг бууруулах</b> ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитад хамрагдсан багийн ажилтнууд нь аюулыг арилгах, ХЭМАБ-ын эрсдэлийг бууруулах, түүний дотор ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах хяналтын арга хэмжээ эсвэл хяналтын арга барилын талаар мэдлэгтэй байна:</p>	<p><b>5.9 Eliminating hazards and reducing OH&amp;S risks</b> Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of the control measures or control methods used to eliminate hazards and reduce OH&amp;S risks, including those relevant to the OH&amp;S technical area, in order to evaluate whether an organization has applied:</p>
<p>- ажлыг ажилтанд тааруулах ба тохирсон хяналтын шатлалын баримтжуулалт ба түүний зохистой хэрэглээ;</p>	<p>- the concept of the hierarchy of control, including adapting work to workers and its appropriate application;</p>



<p>- байгууллагын сонгосон аливаа боломжит сөрөг нөлөөллийг тодорхойлох үр дүнтэй хяналтын арга хэмжээ, түүний дотор гадны үйлчилгээ үзүүлэгчдэд хэрэглэсэн арга хэмжээ.</p>	<p>— the appropriate and effective control measures, including the identification of any potential adverse effects, that have been selected by the organization, including those applied to the external providers.</p>
<p><b>5.10 Ослын судалгаа</b> ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудитад хамрагдаж буй багийн ажилтнууд тухайн байгууллага ослын судалгааг байгууллагын хэмжээнд ба ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээнд үр дүнтэй явуулсан эсэхийг үнэлэхийн тулд ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах ослын судалгааны аргуудын талаар мэдлэгтэй байна. Үүнд:</p>	<p><b>5.10 Incident investigation</b> Personnel on a team involved in OH&amp;S management system auditing shall have knowledge of incident investigation methods, including those relevant to the OH&amp;S technical area, in order to evaluate whether an organization has conducted the investigation effectively in an organizational context and within the scope of the OH&amp;S management system. This includes:</p>
<p>- учир шалтгааны шинжилгээ, алдааны модны шинжилгээ зэрэг ослын судалгааны холбогдох арга, практик;</p>	<p>-the relevant methods and practices for incident investigations, such as root cause analysis, fault tree analysis;</p>
<p>- шалтгааныг арилгах арга хэмжээг тодорхойлох.</p>	<p>-the identification of actions to eliminate the cause(s).</p>
<p><b>6. Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнуудад тавих чадамжийн шаардлага</b></p>	<p><b>6. Competence requirements for personnel reviewing audit reports and making certification decisions</b></p>
<p><b>6.1 ХЭМАБ-ын нэр томъёо, зарчим, үйл явц, ойлголт</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь ХЭМАБ-ын нэр томъёо, зарчим, үйл явц, ойлголтын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдлэгтэй байна. ХЭМАБ болон ХЭМАБ-ын менежментийн нэр томъёо, зарчим, ойлголтод дараах зүйлс орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:</p>	<p><b>6.1 Terminology, principles, processes and concepts of OH&amp;S</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have and shall maintain up to-date knowledge of terminology, principles, processes and concepts of OH&amp;S and OH&amp;S management. Terminology, principles and concepts of OH&amp;S and OH&amp;S management include, but are not limited to:</p>
<p>-ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны төлөвлөсөн үр дүн(үүд);</p>	<p>- intended outcome(s) of the OH&amp;S management system;</p>
<p>- аюул ба ХЭМАБ-ын эрсдэл;</p>	<p>- hazards and OH&amp;S risks;</p>
<p>- эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах эсвэл бууруулах;</p>	<p>- minimizing or reducing risks;</p>
<p>- хяналтын шатлал;</p>	<p>- hierarchy of control;</p>
<p>-худалдан авах ажиллагаа (аутсорсинг, гүйцэтгэгчийг оролцуулан);</p>	<p>- procurement (including outsourcing and contractors);</p>
<p>- гүйцэтгэсэн ажилд хяналт тавих.</p>	<p>- shared control over work performed.</p>

<p><b>6.2 Байгууллагын төлөв байдал</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь аудитын багийг ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны хамрах хүрээ, түүний хил хязгаар, хэрэглэгдэх байдлыг байгууллагын нөхцөл, ажилтай холбоотой үйл ажиллагааны хүрээнд зохих ёсоор баталгаажуулсан эсэхийг тодорхойлохын тул дараахь асуудлаар хангалттай мэдлэгтэй байна:</p>	<p><b>6.2 Context of the organization</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have sufficient knowledge of the following in order to determine if the audit team has appropriately confirmed the scope, including boundaries and applicability of its OH&amp;S management system, within the organization's context and its work related activities:</p>
<p>- байгууллагын төлөв байдалтай холбоотой болзошгүй асуудлууд; - боломжит бусад сонирхогч талууд.</p>	<p>- potential issues relevant to the context of the organization; - potential other interested parties.</p>
<p><b>6.3 Ажилчдын манлайлал, зөвлөлгөөн, оролцоо</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь ажилчдын манлайлал, соёл, зөвлөгөө, оролцоо, хэрэв байгаа бол ажилчдын төлөөлөгчдийн үүрэг, нөлөөллийн талаар мэдлэгтэй байна.</p>	<p><b>6.3 Leadership, consultation and participation of workers</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of the role and impact of leadership, culture, consultation and participation of workers and, when they exist, workers' representatives.</p>
<p><b>6.4 Хуулийн шаардлага ба бусад шаардлага</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр хуулийн шаардлага болон бусад шаардлагыг мэддэг байна.</p>	<p><b>6.4 Legal requirements and other requirements</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall be aware of legal requirements and other requirements in the field of health and safety at work.</p>
<p><b>6.5 ХЭМАБ-ын эрсдэл ба боломж, бусад эрсдэл ба боломж</b> <b>6.5.1 Аюулыг тодорхойлох</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнууд нь ХЭМАБ-ын техникийн салбарт хамаарах аюул, түүнийг илрүүлэх аргуудын талаар мэдлэгтэй байна. Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнууд нь дараах ангиллын аюулын талаар мэдлэгтэй байна:</p>	<p><b>6.5 OH&amp;S risks, OH&amp;S opportunities and other risks and other opportunities</b> <b>6.5.1 Hazard identification</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of hazards and methods for identifying them, including those relevant to the OH&amp;S technical area. Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of the following categories of hazards, including but not limited to, those in the following categories:</p>
<p>- физикийн;</p>	<p>- physical</p>
<p>- химийн;</p>	<p>- chemical;</p>
<p>- биологийн;</p>	<p>- biological;</p>

- физиологийн;	- physiological;
- механикийн;	- mechanical;
- цахилгааны;	- electrical;
- сэтгэлзүйн;	- psychosocial;
- хөдөлгөөн ба энерги дээр суурилсан.	- based on movement and energy.
<p><b>6.5.2 ХЭМАБ-ын эрсдэлийн үнэлгээ</b>  Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь ХЭМАБ-ын эрсдэлийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлт, техникийн мэдлэгтэй байна.</p>	<p><b>6.5.2 Assessment of OH&amp;S risks</b>  Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of the type of methodologies and criteria for the assessment of OH&amp;S risks, including those relevant to the OH&amp;S technical area.</p>
<p><b>6.5.3 ХЭМАБ-ын боломж</b>  Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнууд нь ХЭМАБ-ын боломжийн талаар ойлголттой байна.</p>	<p><b>6.5.3 OH&amp;S opportunities</b>  Personnel reviewing audit reports and making certification decisions shall be aware of concepts of OH&amp;S opportunities.</p>

СТАНДАРТЫН

<p><b>6.6 Гүйцэтгэлийн үнэлгээ</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь ХЭМАБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний аргын талаар мэдлэгтэй байна.</p>	<p><b>6.6 Performance evaluation</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of OH&amp;S performance evaluation methods.</p>
<p><b>6.7 Аюулыг арилгах, ХЭМАБ-ын эрсдэлийг бууруулах</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь хяналтын шатлалын мэдлэгийг эзэмшсэн байна.</p>	<p><b>6.7 Eliminating hazards and reducing OH&amp;S risks</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of the concept of the hierarchy of control.</p>
<p><b>6.8 Ослын судалгаа</b> Аудитын тайланг хянаж, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтан нь ослын судалгааны аргуудын талаар мэдлэгтэй байна.</p>	<p><b>6.8 Incident investigation</b> Personnel reviewing audit reports and making certification decisions shall have knowledge of incident investigation methods.</p>
<p><b>7 Баталгаажуулалтын бусад ажилтанд тавих чадамжийн шаардлага</b></p>	<p><b>7 Competence requirements for other certification personnel</b></p>
<p><b>7.1 ХЭМАБ-ын нэр томъёо, зарчим, үйл явц, ойлголт</b> Өөрийн чиг үүргийн дагуу аудитын багийн шаардлагатай ур чадварыг тодорхойлох, аудитын багийн гишүүдийг сонгох, аудитын цагийг тодорхойлох зорилгоор өргөдлийг хянан шалгаж буй ажилтнууд нь ХЭМАБ-ын нэр томъёо, зарчим, үйл явц ба ойлголтын талаар хамгийн сүүлийн үеийн мэдлэгтэй байна. ХЭМАБ болон ХЭМАБ-ын менежментийн нэр томъёо, зарчим, үйл явц, ойлголт нь дараах зүйлийг агуулдаг боловч үүгээр хязгаарлагдахгүй:</p>	<p><b>7.1 Terminology, principles, processes and concepts of OH&amp;S</b> As appropriate for their function, personnel conducting the application review to determine the audit team competence required, to select the audit team members, and to determine the audit time, shall have and shall maintain up-to-date knowledge of OH&amp;S terminology, principles, processes and concepts. Terminology, principles, processes and concepts of OH&amp;S and OH&amp;S management include, but are not limited to:</p>
<p>- ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны төлөвлөсөн үр дүн(үүд);</p>	<p>- intended outcome(s) of the OH&amp;S management system;</p>
<p>- аюул ба ХЭМАБ-ын эрсдэл;</p>	<p>- hazards and OH&amp;S risks;</p>
<p>- эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах эсвэл бууруулах;</p>	<p>- minimizing or reducing risks;</p>
<p>- хяналтын шатлал;</p>	<p>- hierarchy of control;</p>
<p>- худалдан авах ажиллагаа (аутсорсинг, гүйцэтгэгчийг оролцуулан);</p>	<p>- procurement (including outsourcing and contractors);</p>
<p>- гүйцэтгэсэн ажлын нэгдсэн хяналт.</p>	<p>- shared control over work performed.</p>

<p><b>7.2 Байгууллагын төлөв байдал</b> Өөрийн чиг үүргийн дагуу шаардлагатай аудитын багийн чадамжийг тодорхойлох, аудитын багийн гишүүдийг сонгох, аудитын цагийг тодорхойлох зорилгоор өргөдлийг шалгаж буй ажилтнууд дараах зүйлийг хангана:</p>	<p><b>7.2 Context of the organization</b> As appropriate for their function, personnel conducting the application review to determine the audit team competence required, to select the audit team members, and to determine the audit time, shall have:</p>
<p>- ажлын талбайтай холбоотой хүчин зүйлс, ажлын талбай болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, нарийн төвөгтэй байдлын талаархи мэдлэг, аудитын хугацааг тодорхойлох, чадварлаг аудитын багийг сонгох;</p>	<p>— knowledge of site-related factors, and risks and complexity related to the site and the organization’s activities, to determine the audit time and to select a competent audit team;</p>
<p>- санал болгож буй баталгаажуулалтын хамрах хүрээ нь тухайн байгууллагын нөхцөл, түүний ажилтай холбоотой үйл ажиллагаанд тохирсон болохыг тодорхойлох мэдлэг.</p>	<p>— knowledge to determine that the proposed scope of certification is appropriate within the organization’s context and its work related activities.</p>

СТАНДАРТЫН ТӨВӨГ

**Хавсралт А  
(мэдээллийн)**

ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтын талаарх мэдлэг  
Хүснэгт А.1-д ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалтад шаардагдах мэдлэгийн хураангуйг харуулав.

Хүснэгт А.1 — ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны аудит ба баталгаажуулалтын талаарх мэдлэг

Мэдлэг	Баталгаажуулалтын чиг үүрэг		
	Аудитын багт шаардлагатай чадамжийг тодорхойлох, аудитын багийн гишүүдийг сонгох, аудитын хугацааг тогтоохоор өргөдлийн дүн шинжилгээ хийх	Аудитын тайланд дүн шинжилгээ хийх болон баталгаажуулалтын шийдвэр гаргах	Аудитыг гүйцэтгэх болон аудитын багийг ахлах
ХЭМАБ-ын нэр томъёо, зарчим, үйл явц, ойлголт	X (7.1 үзэх)	X (6.1-ийг үзэх)	X (5.2-ыг үзэх)
Байгууллагын төлөв байдал	X (7.2 үзэх)	X (6.2-ыг үзэх)	X (5.3-ыг үзэх)
Удирдлага, зөвлөлгөөн, ажилтнуудын оролцоо		X (6.3-ыг үзэх)	X (5.4-ийг үзэх)
Хуулийн шаардлага ба бусад шаардлага		X (6.4-ийг үзэх)	X (5.5-ыг үзэх)
ХЭМАБ-ын эрсдэл, ХЭМАБ-ын боломж болон бусад эрсдэл ба боломж		X (6.5-ыг үзэх)	X (5.6-г үзэх)
Аюулыг тодорхойлох		X (6.5.1-ийг үзэх)	X (5.6.2-ыг үзэх)
ХЭМАБ-ын эрсдэлийн үнэлгээ		X (6.5.2-ыг үзэх)	X (5.6.3-ыг үзэх)
ХЭМАБ-ын боломж		X (6.5.3-ыг үзэх)	X (5.6.4-ийг үзэх)
Онцгой байдлын бэлэн байдал болон хариу арга хэмжээ			X (5.7-г үзэх)
Гүйцэтгэлийн үнэлгээ		X (6.6-г үзэх)	X (5.8-ыг үзэх)
Аюулыг арилгах, ХЭМАБ-ын эрсдэлийг бууруулах		X (6.7-г үзэх)	X (5.9-ийг үзэх)

Ослын судалгаа		X (6.8-ыг үзэх)	X (5.10-ыг үзэх)
----------------	--	-----------------	------------------

**Annex A  
(informative)**

Knowledge for OH&S management systems auditing and certification Table A.1 provides a summary of the knowledge required for OH&S management systems auditing and certification.

Table A.1 — Knowledge for OH&S management system auditing and certification

Knowledge	Certification functions		
	Conducting the application review to determine audit team competence required, to select the audit team members, and to determine the audit time	Reviewing audit reports and making certification decisions	Auditing and leading the audit team
OH&S terminology, principles, processes and concepts	X (see 7.1)	X (see 6.1)	X (see 5.2)
Context of the organization	X (see 7.2)	X (see 6.2)	X (see 5.3)
Leadership, consultation and participation of workers		X (see 6.3)	X (see 5.4)
Legal requirements and other requirements		X (see 6.4)	X (see 5.5)
OH&S risks, OH&S opportunities and other risks and other opportunities		X (see 6.5)	X (see 5.6)
Hazard identification		X (see 6.5.1)	X (see 5.6.2)
Assessment of OH&S risks		X (see 6.5.2)	X (see 5.6.3)
OH&S opportunities		X (see 6.5.3)	X (see 5.6.4)
Emergency preparedness and response			X (see 5.7)
Performance evaluation		X (see 6.6)	X (see 5.8)
Eliminating hazards and reducing OH&S risks		X (see 6.7)	X (see 5.9)
Incident investigation		X (see 6.8)	X (see 5.10)

СТАНДАРТТЫҢ ТӨСӨГ